

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/ /Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: “ЛэндМН ББСБ” ХК УБГД: 000166216 Үнэт цаасны код: MN0LEND05453 Утасны дугаар: 77070101, 77222949
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Санхүүгийн салбар – банк бус санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	800,000,000 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр /Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/	Хагас жилийн тайланг бэлтгэсэн: Хуулийн мэргэжилтэн Б.Ганзул Хагас жилийн тайланг хянасан: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Х.Хулан

1.	Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ /Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/						
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хавсаргав.					
	Орлогын тайлан						
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмчийн өөрчлөлтийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Бусад нөөц	Х.ашиг	Нийт эздийн өмч
		2025.06.30-ний өдрийн байдлаар	5.7	2.8	0.1	73.3	81.8
		Тайлан үеийн цэвэр ашиг				19.9	19.9
		Ногдол ашиг					(11.0)
		Халаасны хувьцаа					
		2025.12.31-ний өдрийн байдлаар	5.7	2.8	0.1	93.2	101.7
		Тайлан үеийн цэвэр ашиг				18.4	18.4
		Ногдол ашиг				(12.2)	(12.2)
		Халаасны хувьцаа					

		2026.06.30- ний өдрийн байдлаар	5.7	2.8	0.1	99.4	107.9																										
	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	<table><tr><th>Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/</th><th>2024Н1</th><th>2025Н1</th><th>2026Н1</th></tr><tr><td>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</td><td>1.4</td><td>12.3</td><td>10.6</td></tr><tr><td>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</td><td>(0.3)</td><td>6.0</td><td>(23.8)</td></tr><tr><td>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</td><td>9.2</td><td>-18.3</td><td>17.0</td></tr><tr><td>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт</td><td>10.3</td><td>1.4</td><td>3.8</td></tr><tr><td>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</td><td>8.6</td><td>12.4</td><td>15.2</td></tr><tr><td>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</td><td>18.9</td><td>12.5</td><td>19.0</td></tr></table>	Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2024Н1	2025Н1	2026Н1	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1.4	12.3	10.6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.3)	6.0	(23.8)	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	9.2	-18.3	17.0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	10.3	1.4	3.8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8.6	12.4	15.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18.9	12.5	19.0			
Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2024Н1	2025Н1	2026Н1																														
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1.4	12.3	10.6																														
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.3)	6.0	(23.8)																														
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	9.2	-18.3	17.0																														
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	10.3	1.4	3.8																														
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8.6	12.4	15.2																														
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18.9	12.5	19.0																														
2.	<i>Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i> <i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>																																
	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хавсаргав.																																
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>																																

3.1

Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

2026 оны эхний хагас жилийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал:

Зээлийн багц
/тэрбум төгрөг/

+19.8%

Бизнесийн зээл

Хэрэглээний зээл

180.0
30.5
149.5

279.3
78.0
201.3

334.6
154.4
180.2

2024H1

2025H1

2026H1

Нийт актив, пассив
/тэрбум төгрөг/

+30.2%

Эздийн өмч

Өр төлбөр

201.2
53.9
147.3

291.4
82.1
209.3

379.5
107.9
271.6

2024H1

2025H1

2026H1

Түүнчлэн 2026 оны эхний хагас жилийн зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2025 оны хагас жилтэй харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 78.0%, зээлийн багц 19.8%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт орлого
/тэрбум төгрөг/

+28.7%

39.7

62.1

79.9

2024H1

2025H1

2026H1

Цэвэр ашиг
/тэрбум төгрөг/

-10.6%

17.1

20.3

18.1

2024H1

2025H1

2026H1

3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл ба Байгал орчин, нийгэм, засаглал (цаашид “БОНЗ”)-ын удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилладаг болно. Тухайлбал, Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 10.0%-с доошгүй байх шаардлагатайгаас 27.4%, Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 20.0%-с доошгүй байх шаардлагатайгаас 33.6%, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 8.0%-с дээш байх шаардлагатайгаас 25.6% тус тус байна
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН”) нь технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болох бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан уян хатан, цогц экосистемийг бүрдүүлэн ажиллаж байна. 2026 оны эхний хагас жилд бид “бизнесийн зээл”-ийн багцыг нэмэгдүүлэхэд төвлөрч, LendMN аппликейшнээр дамжуулан “FlexiBusiness” барьцаагүй, дижитал зээлийн бүтээгдэхүүнийг 15,000 гаруй хувиараа бизнес эрхлэгчдэд олгоод байна. Ийнхүү тус бизнес эрхлэгчдийн 93% нь санхүүжилт авснаар борлуулалтын орлогоо өсгөж, 38% нь шинээр ажлын байр бий болгосон эерэг үзүүлэлттэй байна. - Бид хувь бизнес эрхлэгчдээс гадна жижиг, дунд компаниудад тулгардаг барьцаагүй, шуурхай санхүүжилтийн хэрэгцээг хангах зорилгоор 2026 оны 5 дугаар сард “FlexiBusiness” компанид зориулсан бүтээгдэхүүнээ албан ёсоор зах зээлд танилцууллаа. Компаниуд одоо https://e-lend.mn вэб сайтаар дамжуулан дансаа холбон зээлийн эрхээ шууд тооцоолуулах, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран онлайнаар зээл авах, эргэн төлөлтөө дижиталаар бүрэн шийдвэрлэх боломжтой болов. Энэхүү шийдэл нь компаниудын банк, санхүүгийн байгууллагад зарцуулах цаг хугацааг хэмнэж, бизнесээ дараагийн шатанд гаргахад нь бодит дэмжлэг болж байна. - Бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгө болон зардлын удирдлагыг хөнгөвчлөх зорилгоор бид LendDy “Хүссэнээ аваад хүслээрээ төлөх” (BNPL) бүтээгдэхүүнийхээ цар хүрээг өргөжүүллээ. Бизнес эрхлэгч иргэн болон компаниуд өөрсдийн түрээс, тээвэр зэрэг тогтмол зардлуудыг LendDy-ээр дамжуулан санхүүжүүлэх боломжийг бид бүрдүүлж байна. - Үүний нэгэн тод жишээ нь тээвэр, логистикийн салбарт тэргүүлэгч “Монложистикс Групп”-тэй хийсэн хамтын ажиллагаа юм. Уг түншлэлийн хүрээнд тээвэрлэлтийн зардлыг технологид суурилсан санхүүгийн шийдлээр илүү хурдан, хялбараар төлөх нөхцөлийг харилцагчдадаа санал болгож эхэллээ. - Бид ирээдүйд бизнес эрхлэгчдийнхээ түрээсийн төлбөр, цалингийн зардал, бараа материалын татан авалт болон бусад үйл ажиллагааны зардлуудыг хамгийн хялбар бөгөөд оновчтой аргаар санхүүжүүлэх боломжуудыг тасралтгүй эрэлхийлж, үйлчилгээнийхээ нэр төрлийг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна. - ЛэндМН нь 2026 оны эхний хагас жилд нийт 13.19 тэрбум төгрөгийн бондын эргэн төлөлтийг гүйцэтгэж, нийт 16 удаагийн бондын хүүгийн төлөлтийг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.

3.4

Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй болно.

4.

Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/

4.1 Их хэмжээний хэлцэл

Тайлант хугацааны турш их хэмжээний хэлцэл хийгээгүй.

4.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл

2026 оны эхний хагас жилийн байдлаар Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг санхүүжүүлэх үүднээс хоёрдогч өглөг авах болон Компанийн үйлчилгээг технологиор дамжуулан хүргэх, аппликейшний хөгжүүлэлт, засан сайжруулалтыг тогтмол хангахтай холбоотойгоор нийт 5 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгогдож, эдгээр хэлцлийг байгуулсан байна.

Үүнд:

№	Хэлцлийн нөгөө тал	Зөвшөөрөл олгосон огноо	Хэлцэл хийсэн зорилго
1	“АНД Системс Тех” ХХК	2026.02.06	Компани нь нэг нэгдлийн оролцогч компани болох "АНД Системс Тех" ХХК-аас шинэчлэгдсэн скорингийг өөрийн үйл ажилагаанд авч ашиглах зорилгоор Credit Scoring хөгжүүлэлтийн гэрээг хийсэн.
2	“АНД Сольюшн” Пти.Лтд	2026.02.06	Компани нь нэг нэгдлийн оролцогч компани болох “АНД Сольюшн” Пти.Лтд-тэй байгуулсан 2021/38 тоот “Системийн программ хангамжийн үйлчилгээний гэрээ”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, скоринг хэсгийг хассан.
3	“АНД Системс” ХХК	2026.02.06	Компанийн толгой компани болох “АНД Системс” ХХК-аас Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор 10,740,000,000 төгрөгийг хоёрдогч өглөг хэлбэрээр авсан.
4	“АНД Системс Тех” ХХК	2026.04.30	“АНД Сольюшн” Пти.Лтд-ийн зүгээс 2021/38 тоот “Программ хангамжийн

			үйлчилгээний гэрээ”-ний хүрээнд үзүүлж буй технологийн үйлчилгээг цаашид Компанийн нэг нэгдлийн оролцогч компани болох “АНД Системс Тех” ХХК-аар дамжуулан үзүүлэхээр тохиролцсон.	
	5	“АНД Системс” ХХК	2026.04.30	Компанийн толгой компани болох “АНД Системс” ХХК-тай байгуулсан AS-20/27, 2020/07 тоот “Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ”-нд Менежментийн зөвлөх үйлчилгээний ажлын цар хүрээг нарийвчлан тодорхойлсон.
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл			
	ЛэндМН нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.			
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл			
	ЛэндМН нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон бусад зохицуулагч байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журам, засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. ЛэндМН нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор байна. ЛэндМН-ийн зүгээс Хөрөнгө оруулагч, Хувьцаа эзэмшигч болон Харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал, хагас жил, жилийн эцсийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримтлан ажиллаж, тухай бүр тайлан бэлтгэж олон нийтэд хүргээд байна. Тодруулбал, 2025 оны жилийн эцсийн тайланг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр, 2025 оны БОНЗ-ын тайланг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, 2026 оны I улирлын тайланг 2026 оны 05 дугаар сарын 04-ны өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, байгаль орчин, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгоход анхаарч ажилласан болно. 2026 оны эхний хагас жилийн хугацаанд ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.			

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ЛэндМН нь 9 дэх жилдээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тасалдуулахгүй амжилттай зохион байгуулан ажиллалаа.

Компанийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Галлериа Улаанбаатар төв (Galleria Ulaanbaatar Center)”-ын 3 давхарт байрлах Juulchin Grand Ballroom танхимд зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 81.65% буюу 603,672,804 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм. Үүнд:

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
- Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг батлах;

ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчид хуралдаа идэвхтэй оролцож, ЛэндМН-ийн цаашдын хөгжил болоод үйл ажиллагааны талаар Удирдлагын багаас мэдээлэл авч, мөн өөрийн санал, хүсэлтээ илэрхийлж байв. ЛэндМН-ийн зүгээс өмнөх жилүүдэд ашигласан цахим санал хураалтын системийг энэ удаагийн ХЭЭХ-д ашигласан нь санал хураалтын дүнг түргэн шуурхай гаргах боломжийг бүрдүүлж, хурлын үр дүнтэй Хувьцаа эзэмшигчид богино хугацаанд танилцах боломжийг олгосноороо онцлог байлаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ нь ЛэндМН-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд ЛэндМН-ийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх захиралд компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүнийг сонгосон. ТУЗ-ийн ердийн 6 гишүүнээр Монгол Улсын иргэн О.Болдбаатар, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ, П.Отгонбаяр, С.Энх-Амгалан, Япон Улсын иргэн Кацухико Мадоно нар сонгогдсон бол ТУЗ-ийн Хараат бус 3 гишүүнээр Монгол Улсын иргэн С.Нэргүй, Х.Батсүрэн, Ц.Түмэнцогт нар тус тус сонгогдсон болно. Ийнхүү ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг сонгож, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн болон ТУЗ-ийн 2026 оны ээлжит хурлын хуваарь, ажлын төлөвлөгөөг шинэчлэн баталлаа.

ТУЗ нь 2026 оны хагас жилд 2 удаа ээлжит хурал, 5 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 33 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлээд байна.

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1) Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо, 2) Аудитын хороо, 3) Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 4) Цалин, урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Засаглал, нэр дэвшүүлэх хороо (цаашид “ЗНДХ”)

ЗНДХ-ны даргаар ТУЗ-ийн Хараат бус гишүүн Х.Батсүрэн, гишүүдээр ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ц.Түмэнцогт, ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар нар ажиллаж байна. ЗНДХ нь 2026 оны хагас жилд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, ердийн болон хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах, сонгох асуудлыг хэлэлцэж ажилласан байна.

Цалин, урамшууллын хороо (цаашид “ЦУХ”)

ЦУХ-ны даргаар ТУЗ-ын Хараат бус гишүүн Ц.Түмэнцогт, гишүүдээр ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй, ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар нар ажиллаж байна. ЦУХ нь 2026 оны хагас жилд нийт 1 удаа хуралдаж, ТУЗ-ийн 2026 оны төсвийн асуудлыг Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх асуудлыг хэлэлцэж ажилласан байна.

Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо (цаашид “ЭБОНЗУХ”)

ЭБОНЗУХ-ны даргаар ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар, гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Хос-Эрдэнэ, Ц.Ууганбаяр, Кацухико Мадоно, С.Энх-Амгалан, ТУЗ-ийн Хараат бус гишүүн Х.Батсүрэн нар ажиллаж байна.

ЭБОНЗУХ нь 2026 оны хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих болон БОНЗ-ын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын хороо

Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй, гишүүдээр ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ц.Түмэнцогт, ТУЗ-ийн Ердийн гишүүн П.Отгонбаяр нар ажиллаж байна.

Аудитын хороо нь 2026 оны хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон ЛэндМН-ийн газар, хэлтэс, албадуудад өгч ажиллалаа. Түүнчлэн, ЛэндМН-ийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацааны мэдээлэл

№	ТУЗ-ийн гишүүд	2026 оны эхний хагас жилийн ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	ЛэндМН-д хувьцаа эзэмшдэг эсэх
1	О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 9 дэх жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0079%
2	С.Энх-Амгалан	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 9 дэх жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.09%
3	Кацухико Мадоно	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0036%

4	Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 5 дахь жилдээ ажиллаж байна	Нийт хувьцааны 0.0028%
5	Б.Хос-Эрдэнэ	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 5 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
6	П.Отгонбаяр	100%	ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна	Үгүй
7	С.Нэргүй	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 3 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй
8	Х.Батсүрэн	100%	ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна	Үгүй
9	Ц.Түмэнцогт	100%	ХЭЭХ-аас сонгогдож, эхний жилдээ ажиллаж байна	Үгүй

ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, эсхүл “түдгэлзсэн” санал гаргах боломжтой.

ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд ЛэндМН-ийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад шаардлагатай, ач холбогдол бүхий шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар, дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, ТӨРӨЛ БОЛОН БУСАД МЭДЭЭЛЭЛ

№	Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Баталсан тогтоолын тоо
1	2026 оны 02 дугаар сарын 06	100%	Ээлжит хурал	15
2	2026 оны 03 дугаар сарын 17	100%	Эчнээ санал хураалт	1
3	2026 оны 03 дугаар сарын 26	100%	Эчнээ санал хураалт	1
4	2026 оны 04 дүгээр сарын 17	100%	Эчнээ санал хураалт	1

5	2026 оны 04 дүгээр сарын 30	100%	Ээлжит хурал	12
6	2026 оны 06 дугаар сарын 17	100%	Эчнээ санал хураалт	2
7	2026 оны 06 дугаар сарын 29	100%	Эчнээ санал хураалт	1

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
6	8	9	7	3

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

ЛэндМН-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу жил бүрийн цэвэр ашгаасаа Хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тараадаг билээ.

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар ЛэндМН-ийн 2025 оны цэвэр ашгийн 30.4%-ийг буюу нэгж хувьцаанд 16,5 (арван зургаа аравны тав) төгрөг, нийт 12,198,477,769.5 (арван хоёр тэрбум нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун жаран ес аравны тав) төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд ЛэндМН-ийн зүгээс ногдол ашгийг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд байршуулж ажиллалаа.

7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
----	---

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

ЛэндМН нь компанийн засаглал болон соёлын сайжруулан бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг Санхүүгийн зохицуулах хорооны нэгдсэн үнэлгээний хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах үзүүлэлттэй байна.

№	Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Авсан оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	91.6%

2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5	83.3%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5	83.3%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
	Нэгдсэн дүн	72	63	95.74%

ЛэндМН нь “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг 95,74%-тай хэрэгжүүлэн ажиллаж, “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд үнэлэгдсэн байна.

2026 оны үлдсэн хагаст ЛэндМН нь өөрийн холбогдох баримт бичгүүдийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шинэчлэх, зохицуулалтуудыг “Компанийн засаглалын кодекс”-тэй нийцүүлж, Кодексын хэрэгжилтийг бүрэн хангахын тулд компанийн засаглалын ил тод байдлыг хангаж, ТУЗ-ийн ажлын болон сургалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах болно.

БУСАД ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

2026 оны эхний хагас жилийн байдлаар дараах тайлан, мэдээллүүдийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хугацаанд илгээж, олон нийтэд мэдээлсэн байна. Үүнд:

- 2025 оны жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлан;
- 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2025 оны БОНЗ-ын тайлан
- 2026 оны I улирлын үйл ажиллагааны тайлан;
- 2026 оны хагас жилд ТУЗ-өөс гарсан тогтоолууд;
- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, тэмдэглэл холбогдох баримт бичгүүд;
- Компанийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүд.

Түүнчлэн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Компанийн сошиал сувгууд болон харилцагчийн үйлчилгээний төвийн 77070101 тоот утсаар харилцагч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын санал, хүсэлт, асуултад тухай бүх хариу өгөн ажиллаж, мэдээлэл солилцон ажилласан байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Ууганбаяр

Албан тушаал: “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.Хулан

Албан тушаал: “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Байгууллагын нэр: ЛЭНДМН ББСБ ХК

Регистр: 5039754

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1. ХӨРӨНГӨ	-	-
1.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15,192,047,430.15	19,041,775,127.53
1.2 Зээл	307,709,881,449.59	311,338,728,001.83
1.3 Факторингийн тооцооны авлага	-	-
1.4 Үүсмэл санхүүгийн хөрөнгө	612,210,129.14	1,059,823,385.12
1.5 Хөрөнгө оруулалт	8,959,272,916.09	25,093,253,881.03
1.6 Бусад санхүүгийн хөрөнгө	7,217,597,590.09	22,467,214,842.08
1.7 Санхүүгийн хөрөнгийн дүн	339,691,009,515.06	379,000,795,237.59
1.8 Татвар, НДШ-ийн авлага	201,944,367.61	-
1.9 Үндсэн хөрөнгө	4,202,974,367.95	4,100,791,978.95
1.10 Биет бус хөрөнгө	1,297,664,392.42	1,634,383,404.98
1.11 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.12 Бусад санхүүгийн бус хөрөнгө	1,122,360,600.65	1,118,928,927.59
1.13 Санхүүгийн бус хөрөнгийн дүн	6,824,943,728.63	6,854,104,311.52
1.14 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	346,515,953,243.69	385,854,899,549.11
2. ӨР ТӨЛБӨР	-	-
2.1 Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	67,288,775,798.02	64,385,429,172.23
2.2 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	127,928,855,603.74	147,785,729,136.69
2.3 Бусад эх үүсвэр	21,029,727,169.16	20,601,461,686.49
2.4 Үүсмэл санхүүгийн өр төлбөр	272,168,946.70	272,168,946.70
2.5 Бусад санхүүгийн өр төлбөр	12,693,565,490.98	16,388,682,298.83
2.6 Хоёрдогч өглөг	13,820,236,004.48	24,365,035,300.00
2.7 Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
2.8 Санхүүгийн өр төлбөрийн дүн	243,033,329,013.08	273,798,506,540.94
2.9 Татвар, НДШ-ийн өр төлбөр	1,471,360,065.00	3,683,134,268.66
2.10 Нөөц /Болзошгүй өр төлбөр /	185,031,343.07	314,624,862.09
2.11 Хойшлогдсон татварын өр төлбөр	128,726,346.64	171,375,896.24
2.12 Бусад санхүүгийн бус өр төлбөр	-	-
2.13 Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	1,785,117,754.71	4,169,135,026.99
2.14 НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	244,818,446,767.79	277,967,641,567.93
3. ӨМЧ	-	-
3.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	8,000,000,000.00	8,000,000,000.00
3.2 Өмчийн бусад хэсэг	476,660,181.01	476,660,181.01
3.3 Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	93,220,846,294.89	99,410,597,800.17
3.4 НИЙТ ӨМЧИЙН ДҮН	101,697,506,475.90	107,887,257,981.18
3.5 НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	346,515,953,243.69	385,854,899,549.11
4 Актив	346,515,953,243.69	385,854,899,549.11
5 Пассив	346,515,953,243.69	385,854,899,549.11
6 Зөрүү	-	-

Захирал /Ц.Ууганбаяр/

Нягтлан бодогч /Ч.Саруултуяа/

lendmn

УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

Байгууллагын нэр: ЛЭНДМН ББСБ ХК

Регистр: 5039754

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1.Хүүгийн орлого	-	-
1.1 Банканд байршуулсан хөрөнгийн	166,583,843.92	1,142,588,595.95
1.2 Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	31,669,095.00	89,776,715.63
1.3 Зээлийн	135,190,317,509.00	75,322,777,195.06
1.4 Үнэт цаасны	-	699,680,125.93
1.5 Бусад	-	2,793,204.82
1.6 (Хүүгийн орлогын буцаалт)	-	
1.7.Хүүгийн орлогын дүн	135,388,570,447.92	77,257,615,837.39
2.Хүүгийн зардал	-	
2.1 Итгэлцлийн үр шим	12,043,743,042.43	6,036,914,266.84
2.2 Зээлийн	18,626,734,817.13	18,859,621,521.63
2.3 Үнэт цаасны	5,740,799,590.93	1,613,969,519.98
2.4 Бусад	607,615,714.45	243,806,383.54
2.5 (Хүүгийн зардлын буцаалт)	-	
2.6.Хүүгийн зардлын дүн	37,018,893,164.94	26,754,311,691.99
3.Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)	98,369,677,282.98	50,503,304,145.40
4.Эрсдэлийн сангийн зардал	31,629,363,836.40	19,087,117,922.89
5.Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)	66,740,313,446.58	31,416,186,222.51
6.Бусад орлого	4,540,458,819.90	4,656,194,725.58
6.1 Хүүгийн бус орлого	4,116,493,144.49	3,771,602,617.22
6.2 Бусад орлого, олз	423,965,675.41	884,592,108.36
7.Бусад зардал	22,251,826,647.08	12,766,771,927.61
7.1 Хүүгийн бус зардал	21,293,093,851.30	11,019,266,700.32
7.2 Бусад зардал, гарз	958,732,795.78	1,747,505,227.29
8.Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	49,028,945,619.40	23,305,609,020.48
9.Орлогын татварын зардал	8,883,690,156.54	4,917,379,745.70
10.Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	40,145,255,462.86	18,388,229,274.78
11.Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	
12.Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	40,145,255,462.86	18,388,229,274.78
13.Бусад дэлгэрэнгүй орлого	-	
14.Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)	40,145,255,462.86	18,388,229,274.78



Захирал/Ц.Ууганбаяр/

Нягтлан бодогч/Ч.Саруултуяа/

Байгууллагын нэр: ЛЭНДМН ББСБ ХК

Регистр: 5039754

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-
2 Залруулсан үлдэгдэл	8,000,000,000.00	2,756,858,750.00	-2,337,546,728.69	-	57,348,159.70	64,165,116,077.03	-
3 Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	40,145,255,462.86	40,145,255,462.86
4 Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
5 Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
6 Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	-11,089,525,245.00	- 11,089,525,245.00
7 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
8 20... ОНЫ-Р САРЫННЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ	8,000,000,000.00	2,756,858,750.00	-2,337,546,728.69	-	57,348,159.70	93,220,846,294.89	101,697,506,475.90
9 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-
10 Залруулсан үлдэгдэл	8,000,000,000.00	2,756,858,750.00	-2,337,546,728.69	-	57,348,159.70	93,220,846,294.89	-
11 Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	18,388,229,274.78	18,388,229,274.78
12 Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
13 Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
14 Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	-12,198,477,769.50	- 12,198,477,769.50
15 Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
16 20... ОНЫ-Р САРЫННЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ	8,000,000,000.00	2,756,858,750.00	-2,337,546,728.69	-	57,348,159.70	99,410,597,800.17	107,887,257,981.18



Захирал/Ц.Ууганбаяр/

Нягтлан бодогч/Ч.Саруултуяа/

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1.1 Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	1,201,692,544,172.32	582,515,314,859.63
1.2 Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	74,974,052,731.83	29,421,933,774.00
1.3 Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан	-	-
1.4 Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан	-	-
1.5 Бусад	11,172,082,900.00	-
1.6 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	1,287,838,679,804.15	611,937,248,633.63
1.7 Олгосон зээл	1,171,494,503,750.80	524,175,424,018.19
1.8 Буцаан олгосон итгэлцэл, үр шим	111,955,649,776.46	46,515,122,649.00
1.9 Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн	-	-
1.10 Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн	-	-
1.11 Ажиллагсад олгосон	5,010,237,100.97	3,120,784,640.00
1.12 Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	19,070,541,613.99	7,942,092,985.00
1.13 Ашиглалтын зардалд төлсөн	38,814,343.26	26,690,544.00
1.14 Бусад	12,444,529,162.49	19,531,401,497.39
1.15 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	1,320,014,275,747.97	601,311,516,333.58
1.16 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 32,175,595,943.82	10,625,732,300.05
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1 Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
2.2 Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	-	-
2.3 Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
2.4 Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан	-	26,674,018,548.00
2.5 Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.6 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	-	26,674,018,548.00
2.7 Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,403,695,298.92	292,464,551.00
2.8 Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	3,506,645,947.56	-
2.9 Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.10 Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	33,000,000.00	50,178,202,385.00
2.11 Бусад	-	-
2.12 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	4,943,341,246.48	50,470,666,936.00
2.13 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 4,943,341,246.48	- 23,796,648,388.00
3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
3.1 Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	563,715,506,700.00	71,211,129,324.00
3.2 Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	10,780,035,300.00	10,740,000,000.00
3.3 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.4 Бусад	-	-
3.5 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	574,495,542,000.00	81,951,129,324.00
3.6 Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	523,196,328,000.00	58,546,974,015.00
3.7 Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
3.8 Төлсөн ногдол ашиг	11,089,525,245.00	6,386,195,297.00
3.9 Бусад	348,130,007.31	-
3.10 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	534,633,983,252.31	64,933,169,312.00
3.11 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	39,861,558,747.69	17,017,960,012.00
4. Валютын ханшийн зөрүү	519,984.15	2,683,773.33
5. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,743,141,541.54	3,849,727,697.38
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,448,905,888.61	15,192,047,430.15
7. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,192,047,430.15	19,041,775,127.53
8. БЦМГ	2,743,141,541.54	3,849,727,697.38
9. БЦМГ /6-5/	2,743,141,541.54	3,849,727,697.38
10. Зөрүү	-	-



Захирал/Ц. Ууганбаяр/

Нягтлан бодогч/Ч. Саруултуяа/

УЛААНБААТАР ХОТ
5039754 ±1118267206

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ
АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

2026 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

№ АХ-26/10

Улаанбаатар хот

Дүгнэлт гаргах тухай

Хуралдсан газар, хугацаа: 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдөр эчнээ санал хураалт явуулав.

Хуралд оролцсон: Хорооны дарга С.Нэргүй, гишүүн Ц.Түмэнцогт, П.Отгонбаяр нар тус тус оролцов.

Хурлын ирц: 100 хувь


Хэлэлцсэн асуудал: 2026 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.1 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын холбогдох хэсгийг тус тус үндэслэн “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооноос **ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:**

1. Компанийн зүгээс 2026 оны эхний хагас жилийн байдлаарх санхүү, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тоон үзүүлэлтүүдийг бэлтгэж ирүүлсэнтэй ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо танилцсан болохыг тэмдэглэсүгэй.
2. Компанийн 2026 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн санхүүгийн үзүүлэлт, мэдээллүүд нь бодитой тусгагдсан болохыг баталгаажуулсугай.
3. 2026 оны эхний хагас жилийн тайлан болон шаардлагатай бусад мэдээллийг холбогдох журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, олон нийтэд тайлагнан ажиллахыг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.




Ц.ТҮМЭНЦОГТ


П.ОТГОНБАЯР